ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ

ЗУРАГ ТӨСЛИЙН БАРИМТ БИЧГИЙН

МАГАДЛАЛЫН ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ

2025 оны 07 дугаар сарын 23 өдөр

Дугаар 172/2025

Улаанбаатар-16100
Утас: 70001150
Факс: 70007636

Объектын нэр:	Орхон аймаг, Баян-Өндөр сум, Зэст баг, Хойд дугуй дэлгүүрийн уулзвараас Захиргааны 4-р байрны уулзвар - А1001 авто замын уулзвар хүртэлх авто замын засвар шинэчлэлтийн ажлын зураг, төсөв
Объектын байршил:	Орхон аймаг, Баян-Өндөр сум
Хүчин чадал:	1.072 км, 0.197 км
Захиалагч:	Орхон аймгийн Засаг даргын Тамгын газар
Санхүүжилтийн эх үүсвэр:	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт
Зураг төслийн ерөнхий гүйцэтгэгчийн нэр:	“Маяа рафлес групп” ХХК
Регистрийн дугаар:	6464548
Тусгай зөвшөөрлийн хүчинтэй байх хугацаа:	2030.05.21

Зураг төсөл боловсруулах үндэслэл:

Газар эзэмшүүлэх, ашиглуулах эрх, олгосон захирамж, дугаар огноо:	-
Зураг төсөл боловсруулах даалгавар, батлсан албан тушаалтан, дугаар, огноо:	Орхон аймгийн Засаг даргын 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр батлсан Орхон аймаг, Баян-Өндөр сумын доторх хучилттай авто замын техникийн зураг төсөл боловсруулах ажлын даалгавар, № 08/2024,
Зураг төсөл боловсруулах гэрээ, батлсан албан тушаалтан, дугаар, огноо	Орхон аймгийн Засаг даргын Тамгын газар болон “Маяа рафлес групп” ХХК-ийн хооронд 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдөр байгуулсан “Орхон аймаг, Баян-Өндөр сум, Зэст баг, Хойд дугуй дэлгүүрийн уулзвараас Захиргааны 4-р байрны уулзвар - А1001 авто замын уулзвар хүртэлх авто замын засвар шинэчлэлтийн ажил” зураг төсөл боловсруулах үйлчилгээ үзүүлэх гэрээ, № ЗТБ-30/25 Зураг төсөл боловсруулах гэрээний үнэ: 19 850 000 төгрөг,

Техникийн нөхцөл:

Техникийн нөхцөл	Олгосон байгууллага	Дугаар, огноо	Хүчинтэй байх хугацаа
-	-	-	-

Зөвшилцсөн байгууллага:

Орхон аймгийн ерөнхий архитектор бөгөөд “Хот байгуулалт, барилга захиалагчийн алба” ОНӨААТҮГ-ын захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч	Ц.Хишигжаргал
Орхон аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын Барилга хот байгуулалтын хэлтсийн дарга	Г.Буянхүү
Орхон аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга	Б.Ганзориг
Онцгой байдлын газрын дарга, Хурандаа	Ш.Баасандорж
Орхон аймгийн Замын цагдаагийн тасгийн дарга, Дэд хурандаа	Х.Одбаяр

Зураг төслийн бүрэлдэхүүн:

Зургийн бүрдэл:	Зураг төслийг гүйцэтгэсэн байгууллагын нэр:	Шалгасан экспертийн нэр:
Авто замын засвар шинэчлэлтийн зураг	“Маяа рафлес групп” ХХК	Г.Чинтөгс
Тайлбар бичиг		
Техникийн шаардлага		
Авто замын засвар шинэчлэлтийн төсөв		Л.Баасанбат

1625040488

Геодезийн тайлан	“Хайлааст инженеринг” ХХК	-
Инженер-геологийн тайлан /Барилгын хөгжлийн төвөөр 2025.06.20-ны өдөр магадлал хийсэн байна./	“Хайлааст инженеринг” ХХК Архив № 05325	-

Ерөнхий дүгнэлт:

Авто зам, замын байгууламжийн чигийн сонголт болон техник-эдийн засгийн үзүүлэлтүүд, зураг төслийн үндсэн төлөвлөлт, шийдэл, хучилтын бүтээцийн талаарх дүгнэлт	**Авто зам, замын байгууламжийн төлөвлөлт, хүчин чадал:** **Авто замын ангилал:** Туслах гудамж зам, Хот тосгоны авто зам, Зорчих хэсгийн өргөн 9.0м, одоо байгаа ногоон байгууламж, явган хүний замын өргөн 2х4.0м байхаар төлөвлөсөн байна. **Авто замын хучилтын хийц:** • Жижиг ширхэглэлтэй асфальтбетон хучилт 30 мм • Суурь асфальтбетон хучилт 40 мм • Тэгшилгээний үе асфальтбетон • Одоо байгаа асфальтбетон хучилт **Явган хүний замын хучилтын хийц:** • Байгалийн чулуун хавтан 40 мм • Элс цементэн багсармал 30 мм • Цементээр бэхжүүлсэн элс хайрган хольц 150 мм
Боловсруулсан зураг төслийн сонгосон шийдэл, магадлалын явцад хийсэн нэмэлт, өөрчлөлтөөс шалтгаалах үр дүнгийн талаарх тодорхой санал, дүгнэлт:	Орон тооны бус экспертийн дүгнэлтийн дагуу зураг төсөлд холбогдох засвар, өөрчлөлтүүдийг оруулж дахин хянуулан баталгаажуулсан байна. Үүнд: Зураг төсөлд: Авто замын засвар шинэчлэлтийн зурагт /2025 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн дүгнэлт/ Төсөвт: Авто замын засвар шинэчлэлтийн төсөвт /2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн дүгнэлт/ Дээрх дүгнэлтүүд нь магадлалын ерөнхий дүгнэлтийн хавсралт болно.
Зураг төслийн талаар явуулж байгаа төрийн нэгдсэн бодлого, хууль тогтоомж, норм норматив баримт бичгийг үндэслэн боловсруулсан төслийн сонгосон шийдэл, төслийг хэрэгжүүлснээр гарах үр дүнгийн талаарх тодорхой санал, дүгнэлт	Зураг төслийг хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа дараах норм, дүрмүүдийг баримтлан боловсруулсан байна. Үүнд: -ЗЗБНбД 22-004 -2016 “Авто зам төсөллөх” -БНбД 30-01-04 “Хот тосгоны төлөвлөлт барилгажилтын норм ба дүрэм” -БНбД 32-01-06 “Хот суурины гудамж, зам төлөвлөлт” -БНбД 32-02-12 “Авто замын гүүр ба хоолой төсөллөх” -ЗЗБНбД 83-25-2023 “Авто замын барилгын төсвийн жишиг норм” -ЗЗБНбД 83-28-2023 “Төмөрбетон гүүр, хоолойн барилгын төсвийн жишиг норм” -ЗЗБНбД 83-26-2023 “Авто замын засвар арчлалтын төсвийн жишиг норм” -ЗЗБНбД 81-013-2019 “Авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлын төсөв бодох норм” -АЗУАГН 2.01.01-2004 “Авто замын уур амьсгал, геотехникийн нөхцөл” -MNS 4596:2014 “Авто замын тэмдэг, тэмдэглэл, гэрлэн дохио, хашилт, чиглүүлэх хэрэгслүүдийг хэрэглэх дүрэм” -MNS 4759:2014 “Замын тэмдэглэл. Техникийн ерөнхий шаардлага” -MNS 4597:2014 “Замын тэмдэг. Техникийн ерөнхий шаардлага”
Эдийн засгийн үр ашиг, хөдөлгөөний аюулгүй байдал, экологийн хор хөнөөлгүй байдал, ашиглалтын үеийн найдвартай ажиллагаа, төсөвт өртгийн тооцооны талаарх дүгнэлт	Төсвийг орон тооны бус эксперт дараах байдлаар хянаж баталгаажуулсан байна. Авто замын засвар шинэчлэлтийн ажлын төсөв **3 803 309 309** төгрөг, Төсвийн нийт тооцоо, иж бүрдлийг хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа үнэ бүрдлийн норм, нормативын дагуу тооцсон болохыг хянав.

“Авто замын тухай” хуулийн 19 дүгээр зүйлийн 19.4, 19.5 дахь заалтад заасны дагуу Авто зам, замын байгууламжийн зураг төслийн алдааг зураг төсөл боловсруулсан байгууллага, зохиогч

хариуцах ба зураг төслийн техникийн шийдэл болон төсөвт өртгийн тооцооны талаар гаргасан дүгнэлтийн алдааг магадлал хийсэн этгээд хариуцна.

Орхон аймаг, Баян-Өндөр сум, Зэст баг, Хойд дугуй дэлгүүрийн уулзвараас Захиргааны 4-р байрны уулзвар - А1001 авто замын уулзвар хүртэлх авто замын засвар шинэчлэлтийн ажлын зураг, төсвийн баримт бичгийг холбогдох нормуудын шаардлагад нийцүүлэн төлөвлөсөн бөгөөд уг зураг төслөөр авто замын ажил гүйцэтгэх боломжтой гэж дүгнэж байна.

Тус зураг, төсвийн баримт бичиг "Зам, замын байгууламжийн зураг төсөлд магадлал хийх үйл ажиллагааг зохион байгуулах журам"-ын дагуу магадлалын ерөнхий дүгнэлт бичсэн болно.

Магадлалын ерөнхий дүгнэлт нь орон тооны бус экспертүүдийн гаргасан дүгнэлтийн хамт хүчинтэй. (Хавсралт: 6 хуудас)

"ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ" ТӨҮГ-ЫН ЗАХИРАЛ Д.ОЮУНБОЛД

БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ, ЗУРАГ ТӨСЛИЙН МАГАДЛАЛ, СТАНДАРТ, НОРМ, НОРМАТИВЫН ХЭЛТСИЙН ДАРГА Э.БАЛТ

БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ, ЗУРАГ ТӨСЛИЙН МАГАДЛАЛ, СТАНДАРТ, НОРМ НОРМАТИВЫН ХЭЛТСИЙН ЗУРАГ ТӨСЛИЙН МАГАДЛАЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН Э.ЭНХТӨГС

Зураг төслийн баримт бичгийн
МАГАДЛАЛЫН ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТИЙН ХАВСРАЛТ №1

ЗУРАГ ТӨСЛИЙН БҮРДЛИЙН ХЭСГИЙН НЭР, МАРК, ХУУДАСНЫ ТОО

Авто замын зураг төсөл

2025 оны 07 сарын 07 өдөр

Д/д	Утга	Тайлбар
1	Обьектын нэр	Орхон аймаг, Баян-Өндөр сум, Зэст баг, Хойд дугуй дэлгүүрийн уулзвараас - Захиргааны 4-р байр - А1001 авто замын уулзвар хүртэлх авто замын засвар шинэчлэлтийн ажил
2	Обьектын байршил, хүчин чадал	Орхон аймаг, Баян-Өндөр сум, Зэст баг баг/хороо; 1,19 км
3	Зураг төслийн байгууллага	"Маяа рафлес групп" ХХК
	3. Дүгнэлтийн төвч утга: /Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 204 дүгээр тогтоолын 7-р зүйлээс/	
4	9.9.1 авто зам, замын байгууламжийн байршил тогтоосон шийдвэр, зураг төсөл боловсруулах даалгавар, техникийн нөхцөл, холбогдох мэргэжлийн байгууллагатай зөвшилцсөн байдал;	- Орхон аймгийн засаг дарга Б.Зоригтбаярын 2024 оны 11 сарын 20-ны өдрийн 08/2024 дугаар бүхий Орхон аймаг, Баян-өндөр сумын доторх хучилттай авто замын техникийн зураг төсөл боловсруулах ажлын даалгавар. - Орхон аймгийн Ерөнхий архитектор бөгөөд "Хот байгуулалт, барилга захиалагчийн алба" ОНӨААТҮГ-ын захиралын үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Хишигжаргал, Орхон аймгийн ГХБХБГ-ын БХБХ-ийн дарга Г.Буянхүү, Орхон аймгийн ЗДТГ-ын дарга Б.Ганзориг, Онцгой байдлын газрын дарга, хурандаа Ш.Баасандорж, Орхон аймгийн "Замын цагдаагийн тасаг"-ийн дарга дэд хурандаа Х.Одбаяр нартай зөвшилцсөн байна.
5	9.9.2. инженерийн шийдэл, бүтэц нь дагаж мөрдөж байгаа норм, дүрэм, стандарт, инженер-геологийн судалгааны дүгнэлт, техникийн нөхцөлийн дагуу зохиогдсон эсэх;	- Инженер-геодезийн хайгуул, судалгааг “Хайлааст инженеринг” ХХК 2025 онд боловсруулсан байна. - Инженер-геологийн хайгуул, судалгааг “Хайлааст инженеринг” ХХК 2025 онд боловсруулж, магадлалаар хянагдсан байна.
6	9.9.3. авто зам, замын байгууламжийн чиглэл, байршил, төлөвлөлт, инженер-геологийн нөхцөл, байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл, сонгосон хувилбарын талаарх дүгнэлт;	- Орхон аймгийн Ерөнхий архитектор бөгөөд "Хот байгуулалт, барилга захиалагчийн алба" ОНӨААТҮГ-ын захиралын үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Хишигжаргал, Орхон аймгийн ГХБХБГ-ын БХБХ-ийн дарга Г.Буянхүү, Орхон аймгийн ЗДТГ-ын дарга Б.Ганзориг, Онцгой байдлын газрын дарга, хурандаа Ш.Баасандорж, Орхон аймгийн "Замын цагдаагийн тасаг"-ийн дарга дэд хурандаа Х.Одбаяр нартай зөвшилцсөн ба Орхон аймгийн засаг дарга Б.Зоригтбаярын 2024 оны 11 сарын 20-ны өдрийн 09/2024 дугаар бүхий Орхон аймаг, Баян-өндөр сумын доторх хучилттай авто замын техникийн зураг төсөл боловсруулах ажлын даалгаварын хүрээнд боловсруулсан тул байршил болон хувилбарын сонгол шаардлагагүй.
7	9.9.4. хөдөлмөр хамгаалал, техникийн аюулгүй ажиллагаа, орчны эрүүл ахуйн байдалд тавигдах стандартын шаардлага болон норм, дүрмийг баримталсан байдал;	Боловсруулсан техникийн шаардлагад тусгасан байна.
	/Монгол улсын Засгийн газрын 108 дугаар тогтоолын 6 дугаар зүйлээс/	
8	6.12.3. барилга байгууламжийн гаднах ерөнхий төрх, архитектурыг хот төлөвлөлтийн шаардлагад нийцүүлэн орчны барилга байгууламжтай уялдуулсан байдал, эзэлхүүн болон талбайг үр ашигтай төлөвлөсөн байдал;	- Орхон аймгийн засаг дарга Б.Зоригтбаярын 2024 оны 11 сарын 20-ны өдрийн 08/2024 дугаар бүхий "Орхон аймаг, Баян-өндөр сумын доторх хучилттай авто замын техникийн зураг төсөл боловсруулах ажлын даалгавар"-ын дагуу төлөвлөсөн байна.
9	6.12.5. барилгын ажлын зохион байгуулалтын болон барилга байгууламжийг буулгах, задлах ажил гүйцэтгэх зураг төсөлд хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны шаардлагыг тусгасан байдал.	Тайлбар бичиг болон техникийн шаардлагад тусгасан байна.
10	6.12.6. инженерийн шугам сүлжээний уртын дагуух төлөвлөлтийн оновчтой шийдэл;	
11	6.12.7. хөгжлийн бэрхшээлтэй иргэд ажиллаж, амьдрах нөхцөлийг хангасан төлөвлөлтийн шийдлийг тусгасан байдал;	Зураг төсөлд тусгасан байна.

Д/д	Утга	Тайлбар
12	6.12.8 Магадлалын дүгнэлтэд хууль тогтоомж, норм, нормативын баримт бичгийг үндэслэн төлөвлөлт, техникийн үндсэн шийдэл, эдийн засгийн үр ашигт мэргэжлийн үнэлэлт өгч, техник-эдийн засгийн үндэслэл, зураг төсөлд нэмж тусгах буюу хасах, өөрчлөх асуудлын талаар товч, тодорхой тусгана.	МАГАДЛАЛЫН ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТИЙН ХАВСРАЛТ №2-г үзнэ үү.

Дүгнэлт бичсэн:

Эксперт № 11-02 /Г.Чинтэгс/.....

MONGOLIA
ЗЗИ-22/014
CONSULTING ENGINEER
CHINTUGS
Galindev
2022-2027

2025 оны 07 сарын 07 өдөр

Зураг төслийн баримт бичгийн МАГАДЛАЛЫН ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТИЙН ХАВСРАЛТ №2

ЗУРАГ ТӨСЛИЙН БҮРДЛИЙН ХЭСГИЙН НЭР

Авто замын зураг төсөл

2025 оны 07 сарын 07 өдөр

Д/д	Утга	Тайлбар
1	Обьектын нэр	Орхон аймаг, Баян-Өндөр сум, Зэст баг, Хойд дугуй дэлгүүрийн уулзвараас - Захиргааны 4-р байр - А1001 авто замын уулзвар хүртэлх авто замын засвар шинэчлэлтийн ажил
2	Обьектын байршил, хүчин чадал	Орхон аймаг, Баян-Өндөр сум, Зэст баг баг/хороо; 1,19 км
3	Зураг төслийн байгууллага	"Маяа рафлес групп" ХХК

Д/д	Экспертийн санал, илэрсэн алдаа зөрчил	Алдаа, зөрчлийг засаж, төсөлд засвар оруулсан тухай тайлбар, танилцуулга
1	Ажлын даалгаварт тусгагдсаны дагуу буюу Инженерийн шугам сүлжээний байгууллагуудтай зөвшилцөх, зохих шийдвэрийг гаргуулж холбогдох инженерийн шугам, сүлжээг хүчитгэх хамгаалах ажлыг тооцох	Захиалагч болон Инженерийн шугам сүлжээний байгууллагуудтай 2025оны 6 сарын17-18нд хуралдан 2 удаагийн хэлэлцүүлэг явуулан санал авсан. Хэлэлцүүлэгт Инженерийн шугам сүлжээний байгууллагуудын шугам сүлжээ нөлөөлөлд өртехгүй тул хурлын тэмдэглэлээр баталгаажуулан зөвшилцсөн. Авто замын засвар шинэчлэлтийн ажлын даалгаврын хавсралтад тусгасны дагуу зөвхөн МХС-ийн нөөц сувагчлал хийхээр зурагт тусгав. Хурлын тэмдэглэл хавсаргав.
2	Ажлын тоо хэмжээнд одоо байгаа авто замын хучилтын эвдрэлийг хэрхэн засах, тэгшилгээний үе хийх зэрэг ажлууд тооцоологдоогүй байгааг дахин хянаж үзэх	Одоо байгаа авто замыг төлөвлөлтийн түвшинтэй уялдуулан тэгшилгээний үе нэмж тооцон хүргүүлэв.
3	Дэвсгэр зурагт хэвтээ эргэлт, уулзвар гарцын радиус, нэмэлт эгнээнүүд, авто машин, автобусны зогсоолын зай хэмжээс зэргийг оруулах	Зай хэмжээний зураг тусгаж өгөв.
4	Туслах зам, орон сууцны доторх замд хурд сааруулагчийг явган хүний гарцнаас 5-10м-ийн зайд байрлуулах.	Захиалагч болон Орхон аймгийн замын цагдаагийн тасагтай зөвшилцсөний үндсэн дээр авто замд хурд сааруулагч төлөвлөгдөөгүй.
5	Дагуу огтлолын зурагт Налуу ба шулууны элементүүдийн тоон тэмдэглэгээг хүнд уншигдахаар засварлах	Налуу ба шулууны элементүүдийн тоон тэмдэглэгээг уншигдахаар засварлан хүргүүлэв.
6	Дагуу огтлолын 6,0% -с их төлөвлөгдөж буй хэсгүүдэд гулсалтын эсрэг арга хэмжээ авч төлөвлөх	Дагуу огтлолын 6,0%-с их төлөвлөгдөж буй хэсэгт халтирхаас хамгаалсан түрхлэг нэмж төлөвлөв.
7	Полимер битумын техникийн шаардлагыг нэмж тусгах	Полимер битумын техникийн шаардлагыг нэмж тусган хүргүүлэв.
8	Ажлын тоо хэмжээг дахин хянаж баталгаажуулах	Ажлын тоо хэмжээг хянаж баталгаажуулан хүргүүлэв.

Дүгнэлт бичиж, биелэлтийг шалгасан эксперт № 11-02 ..... /Г.Чинтөгс/

2025 он 07 сар 07 өдөр

Биелэлтийн тайлбар бичсэн ..... /Т.Батсүрэн/

2025 он 07 сар 08 өдөр

MONGOLIA 33И-22/014 CONSULTING ENGINEER CHINTUGS Galindey 2022-2027

Зураг төслийн баримт бичгийн

МАГАДЛАЛЫН ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТИЙН ХАВСРАЛТ №1

ЗУРАГ ТӨСЛИЙН БҮРДЛИЙН ХЭСГИЙН НЭР /ТӨСВИЙН ТООЦОО/

д/д	Утга	Тайлбар
1	Объектийн байршил, хүчин чадал	Орхон аймаг, Баян-Өндөр сум, Хойд дугуй дэлгүүрийн уулзвар - Захиргааны 4-р байр - А1001 авто хүртэл 1,19км авто замын засвар шинэчлэлтийн ажил Замын урт- 1.19 км.
2	Объектийн нэр, шифр	Орхон аймаг, Баян-Өндөр сум, Хойд дугуй дэлгүүрийн уулзвар - Захиргааны 4-р байр - А1001 авто хүртэл 1,19км авто замын засвар шинэчлэлтийн ажлын төсөв Шифр: МРГ25/04
3	Объектийн бүрдлийн хэсгийн нэр, хуудасны тоо, гүйцэтгэсэн ААН байгуулага	Орхон аймаг, Баян-Өндөр сум, Хойд дугуй дэлгүүрийн уулзвар - Захиргааны 4-р байр - А1001 авто хүртэл 1,19км авто замын засвар шинэчлэлтийн ажлын төсөв-1 дэвтэр Зураг төслийн байгууллага: “МАЯА РАФЛЕС ГРУПП ” ХХК
4	Төсвийн тооцооны программ, төсвийн тооцоог хийсэн байгууллагын нэр, гүйцэтгэсэн инженер	Зам, Тээврийн Хөгжлийн сайдын 2019 оны 7 дугаар Зам, Тээврийн Хөгжлийн сайдын 2019 оны 7 дугаар сарын 31-ний өдрийн 256 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлын төсөв бодох норм” ЗЗБНбД 81-013-2019, 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Автомашинаар ачаа тээвэрлэх 1 тн.км-ийн жишиг тариф”, Ажилчдын тарифт цалинг Зам, Тээврийн сайдын 2024 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн А/243 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлын төсөв бодоход хэрэглэх ажилтны цагийн тарифт цалингийн жишиг”, 2 дугаар хавсралтаар батлагдсан “Авто зам, замын байгууламжийн машин ашиглалтын нэг машин цагийн үнэ”-ийг ашиглан төсөв бодох компьютерийн “Road-Estimator” программ ашиглан төсвийн тооцоог хийсэн байна. Орхон аймаг, Баян-Өндөр сум, Хойд дугуй дэлгүүрийн уулзвар - Захиргааны 4-р байр - А1001 авто хүртэл 1,19км авто замын засвар шинэчлэлтийн ажлын төсвийг “МАЯА РАФЛЕС ГРУПП” ХХК, төсөвчин Т.Батсүрэн, Мэргэшсэн төсөвчин Б.Мөнгөншагай нар хийж гүйцэтгэсэн байна. Магадлалд ирүүлсэн төсвийн дүн- ***3 745 100 955*** төгрөг
5	Авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлын тоо хэмжээг үнэн зөв тодорхойлсон байдал	Зургийн инженерийн тодорхойлсон ажлын тоо хэмжээг төсвийн тооцоонд хавсаргасан байна.
6	Төсвийн тооцоонд ашигласан норм, норматив, үнэ үнэлгээ	Төсвийн тооцоог ЗЗБНбД 83-25-2023, ЗЗБНбД 83-26-2023, ЗЗБНбД 83-28-2023 суурь жишиг нормоор үнэлсэн байна.
7	Төсвийн тооцооны арга, аргачлалын оновчтой байдал, төслөөр тодорхойлсон нөөцийг оновчтой ашигласан байдал	Төсвийн тооцооны иж бүрдэл хангагдсан байна.
8	Төсвийн тооцоо, түүний хэлбэржүүлэлтэд зайлшгүй оруулах шаардлагатай засвар, өөрчлөлт	Төсвийн тооцоонд хавсаргах шаардлагатай материалууд: Үүнд: - Ажлын тоо хэмжээг зургийн инженер, зургийн экспертээр баталгаажуулж магадлалын ерөнхий дүгнэлтийн хариуны хамт ирүүлэх. (боломжгүй тохиолдолд захиалагчаар баталгаажуулах) - Төсөвт голлох материалын тээврийн зайг программын тайлбар бичигт хүснэгтээр, схем зургаар (шороон ордоос, үйлдвэрээс тээвэрлэх) бодитой

		тооцон гаргаж зургийн байгууллагаар баталгаажуулан экспертийн дүгнэлтийн хариуны хамт ирүүлэх - Төсвийн тайлбар бичигт төсөвт голлох материалын үнийн судалгаа, хаанаас худалдан авахаар тооцсон талаарх мэдээллийг программын тайлбар бичигт оруулах Төсвийн тооцоонд дараах өөрчлөлтийг оруулж, дахин хянуулах шаардлагатай. Үүнд: - Төсвийн тайлбар бичгийг алдаатай бичсэн байх тул дахин хянаж засах - Төсвийн тайлбар бичигт материал тээвэрлэх зайг бүрэн гүйцэд бичих - Ажилчдын тарифт цалин, машин цагийн үнийг батлагдсан шинэ тарифаар бодох - Замын боржин чулуун хашлаганы үнийг дахин хянаж зах зээлийн үнийн дагуу тооцох - Жижиг ширхэглэлтэй полимер асфальтбетон хольц, Дунд ширхэглэлтэй полимер асфальтбетон хольцын үнийг хэт өндөр үнээр тооцсон байх тул дахин хянаж засах - Байгалийн чулуун хавтангийн үнийг хэрхэн тооцсон талаарх мэдээлэл, үнийн саналыг төсөвт хавсаргах - Зохист найрлага бүхий элс хайрган хольц нь карьерын материал тул үнийг дахин хянах - Карьераас ашиглах материалын үнийг нэг ижил үнээр тооцох /Жишээ нь: Хөлдөлтөөс хамгаалах үеийн материал гэх мэт/ - Тээврийн зардлын тооцоонд материал тээвэрлэх зайг хайгуул судалгааны үндсэн дээр бодитой тооцох - Нүүлгэн шилжүүлэх зардлын тооцоонд машины тоог хэрхэн тооцсон талаарх мэдээллийг ирүүлэх
	Дүгнэлтийн товч утга	
1	Төсвийн тооцоо нь дагаж мөрдөж буй норм, дүрэм, стандартын дагуу оновчтой зохиогдсон эсэх	Орхон аймаг, Баян-Өндөр сум, Хойд дугуй дэлгүүрийн уулзвар - Захиргааны 4-р байр - А1001 авто хүртэл 1,19км авто замын засвар шинэчлэлтийн ажлын төсвийн тооцоог хүчин төгөлдөр мөрдөж буй төсвийн суурь норм, төсөв бодох нормын дагуу хийж гүйцэтгэсэн байна. Магадлалын дүгнэлтээр тодорхойлсон алдаа дутагдлыг засаж экспертийн дүгнэлтийн хариуг ирүүлсэн тул төсвийг **3 803 309 309** төгрөгөөр хянав.
Дүгнэлт бичсэн: Эксперт №12-03 Л.Баасанбат 2025 оны 7 дугаар сарын 07-ны өдөр		

Эксперт дүгнэлтийг компьютерээр 2 хувь бичиж, гарын үсэг, тамга тэмдгээ дарж баталгаажуулсан байна.

МАГАДЛАЛЫН ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТИЙН ХАВСРАЛТ №2
ЭКСПЕРТИЗИЙН ДҮГНЭЛТИЙН ХАРИУ

ЗУРАГ ТӨСЛИЙН БҮРДЛИЙН ХЭСГИЙН НЭР:

Орхон аймаг, Баян-Өндөр сум, Хойд дугуй дэлгүүрийн уулзвар - Захиргааны 4-р байр - А1001 авто хүртэл 1,19км авто замын засвар шинэчлэлтийн ажил

2025 оны 07 сарын 09-ний өдөр

Д/Д	Утга	Тайлбар
1	Объектын нэр:	Орхон аймаг, Баян-Өндөр сум, Хойд дугуй дэлгүүрийн уулзвар - Захиргааны 4-р байр - А1001 авто хүртэл 1,19км авто замын засвар шинэчлэлтийн ажлын төсөв
2	Объектын байршил, хүчин чадал:	Орхон аймаг, Баян-Өндөр сум 1,19 км.
3	Зураг төслийн байгууллага:	“МАЯА РАФЛЕС ГРУПП ” ХХК
д/д	*Экспертийн санал, илэрсэн алдаа зөрчил*	*Алдаа, зөрчлийг засаж, төсөлд засвар оруулсан тухай тайлбар, танилцуулга*
1	Төсвийн тайлбар бичгийг алдаатай бичсэн байх тул дахин хянаж засах	Алдаа зөрчилийг засаж хүргүүлэв
2	Төсвийн тайлбар бичигт материал тээвэрлэх зайг бүрэн гүйцэд бичих	Төсвийн тайлбар бичигт тээвэрлэх зайг бүрэн бичиж хүргүүлэв.
3	Ажилчдын тарифт цалин, машин цагийн үнийг батлагдсан шинэ тарифаар бодох	Шинээр батлагдсан тарифаар засаж тооцон хүргүүлэв.
4	Замын боржин чулуун хашлаганы үнийг дахин хянаж зах зээлийн үнийн дагуу тооцох	Үнийг зах зээлийн ханшийн дагуу тооцон хүргүүлэв.
5	Жижиг ширхэглэлтэй полимер асфальтбетон хольц, Дунд ширхэглэлтэй полимер асфальтбетон хольцын үнийг хэт өндөр үнээр тооцсон байх тул дахин хянаж засах	Полимер асфальтбетон хольцын үнийг дахин хянан засаж хүргүүлэв.
6	Байгалийн чулуун хавтангийн үнийг хэрхэн тооцсон талаарх мэдээлэл, үнийн саналыг төсөвт хавсаргах	Монголын чулуучдын холбоо болон чулууны үйлдвэрээс үнийн санал аван зах зээлийн бодит үнээр тооцов.
7	Зохист найрлага бүхий элс хайрган хольц нь карьерын материал тул үнийг дахин хянах	Сүүлд батлагдсан тушаалын дагуу хянаж засаж тооцон хүргүүлэв.
8	Карьераас ашиглах материалын үнийг нэг ижил үнээр тооцох /Жишээ нь: Хөлдөлтөөс хамгаалах үеийн материал гэх мэт/	Сүүлд батлагдсан тушаалын дагуу хянаж засаж тооцон хүргүүлэв.
9	Тээврийн зардлын тооцоонд материал тээвэрлэх зайг хайгуул судалгааны үндсэн дээр бодитой тооцох	Тээврийн зайг засан бодит зайгаар тооцон хүргүүлэв
10	Нүүлгэн шилжүүлэх зардлын тооцоонд машины тоог хэрхэн тооцсон талаарх мэдээллийг ирүүлэх	Ажилбаруудад гол шаардагдах машин механизмыг нүүлгэн шилжүүлхээр тооцон хүргүүлэв.

Дүгнэлт бичиж,биелэлтийг шалгасан эксперт № ..... */Л.Баасанбат/*

2025 оны 07-р сарын 09-ний өдөр

Биелэлтийн тайлбар бичсэн Мэргэшсэн төсөвчин ..... Б.Мөнгөншагай

2025 оны 07-р сарын 09-ний өдөр